

## БОНЗ, ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАНГИЙН БАТАЛГААЖУУЛАЛТЫН АРГА ЗҮЙН АСУУДАЛ

*Д. Нямаа<sup>\*</sup>, Н. Баярчимэг<sup>\*\*</sup>*

**Хураангуй:** Дэлхий даяарх компаниуд байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын стратеги, гүйцэтгэлийнхээ талаар мэдээлэхийг зорих болсон тул тогтвортой байдлын тайлагнал нь корпорацийн ил тод байдлын санаачилгын чухал хэсэг болсон. Энэхүү оорчлолтийн дүнд тогтвортой байдлын тайлангийн баталгаатай болон найдвартай байдлыг нэмэгдүүлэх баталгаажуулалтын үйлчилгээний хэрэгцээ улам бүр нэмэгдэж байна. Тогтвортой байдлын тайлангийн баталгааг хөгжүүлэх арга зам улс орнуудад харилцан адилгүй байдаг бөгөөд энэ нь маш олон сорилттой тулгарсаар байна. Энэхүү өгүүлэлд практикт тулгарч буй асуудлуудыг судлан тогтоож, сүүлийн үеийн судалгааны чиг хандлага, арга зүй, аргачлалд үндэслэн компаниудын тогтвортой байдлын тайлангийн баталгаажуулалтыг сайжруулах арга замыг тодорхойлох зорилгоор хийсэн судалгааны үр дүнг харуулахыг зорьсон болно.

**Түхүүр үгс:** БОНЗ, Тогтвортой байдал, Тогтвортой байдлын тайлангийн баталгаажуулалт

## METHODOLOGICAL ISSUES FOR ASSURANCE OF SUSTAINABILITY AND ESG REPORTING

**Abstract:** Sustainability reporting has become a pivotal aspect of corporate transparency initiatives, as worldwide companies aim to convey their environmental, social, and governance (ESG) strategies and performance. In this change, the necessity for assurance services that enhance the credibility and dependability of sustainability reports is increasingly recognized. The way that the assurance of sustainability reporting has developed varies among different countries, and it continues to encounter a multitude of challenges. This article discusses the types of assurance, the latest research trends, approaches, methodologies being developed, practical issues, and solutions.

**Key words:** ESG, Sustainability, Assurance of sustainability reporting

---

\* МУИС, Бизнесийн сургууль, (E-mail): [d.nyamaa@num.edu.mn](mailto:d.nyamaa@num.edu.mn)

\*\* МУИС, Бизнесийн сургууль, (E-mail): [bayarchimeg.ner@gmail.com](mailto:bayarchimeg.ner@gmail.com)

## Оршил

Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлт, эдийн засаг, хүн амын хурдацтай өсөлт, байгаль орчны бохирдол зэрэг нь экосистемийн тэнцвэрт байдал алдагдахад хүргэж, улс орнуудын тогтвортой хөгжилд томоохон сорилт болж байна. Иймд сүүлийн жилүүдэд компанийн санхүүгийн гүйцэтгэлээс гадна байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийн асуудал чухлаар тавигдаж, хөрөнгө оруулагчид болон оролцогч талуудын шаардлагаар томоохон байгууллагууд тогтвортой байдлын тайланг гаргах болсон.

Тогтвортой байдлын тайлагнал гэдэг нь дэлхийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартуудын дагуу байгууллагынхаа үйл ажиллагааны эдийн засаг, байгаль орчин, нийгэмд үзүүлж болзошгүй нөлөөллийн талаар олон нийтэд мэдээлж байх байгууллагын хэвшүүлэх дадал юм. Ийнхүү ил тод байснаар байгууллагууд БОНЗ-д үзүүлж буй өөрийн нөлөөллийг тодорхойлох, танин мэдэх, мэдээлэх, улмаар зорилгоо тодорхойлох, өөрчлөлтийг илүү үр дүнтэй удирдах боломжийг бүрдүүлнэ (Тайлагналын Олон Улсын Санаачилга – “ТОУС”).

Нэгдсэн нэг арга зүй, стандарт байхгүйгээс тайлангуудыг харьцуулах боломжгүй, мэдээллийн найдвартай байдалтай холбоотой асуудлууд үүсч байгаагаас санхүүгийн аудит хийдэгтэй нэгэн адил тогтвортой байдлын тайланд баталгаа гаргуулах эрэлт хэрэгцээ үүсээд байна.

Тогтвортой байдлын тайлангийн баталгаажуулалт нь тухайн байгууллагаас гаргасан тогтвортой байдлын тайлангийн талаар гуравдагч этгээдийн баталгаажуулалт хийх үүрэг оролцоо гэж тодорхойлогддог. (Farooq and De Villiers, 2019). Тогтвортой байдлын тайланд баталгаажуулалтын тайланг дурдсанаар тогтвортой байдлын тайлангийн хэрэглэгчид нь уг тайланг тохиролцсон шалгуурын дагуу бэлтгэсэн эсэхийг мэдэх болно.

Санхүүгийн тайлангийн заавал тайлагнах ёстой шинж чанараас ялгаатай нь тогтвортой байдлын мэдээллийг сайн дурын үндсэн дээр тайлагнадаг тул эдгээр тайланд тусгагдсан нийгмийн гүйцэтгэлийн үзүүлэлтүүд нь статистикийн арга барил, ил тод байдлын зэрэглэлээр ялгаатай байж, улмаар тэдгээрийг шалгахад төвөгтэй болгож, найдвартай байдалтай холбоотой асуудал үүсгэж байна. Тогтвортой байдлын тайлангийн баталгаажуулалтын үйлчилгээ шаардлагатай байгууллагуудын тоо өсч байгаа боловч энэ чиглэлээр судалгаа хомс байна.

Энэхүү судалгаанд дотоодын болон гадаадын тогтвортой байдлын баталгаажуулалтын тогтолцоог харьцуулан судалж, манай орны тогтвортой байдлын тайлангийн баталгаажуулалтын тогтолцоонд тулгамдаж буй асуудлыг тодорхойлох бөгөөд судалгааны үр дүнд үндэслэн тулгамдсан зарим асуудлыг сайжруулах, шийдвэрлэх санал боловсруулна.

### Тогтвортой байдлын тайлангийн баталгааны эрэлт

Тогтвортой байдлын тайлангийн баталгааны эрэлт хэрэгцээ өсч буй нь хөрөнгө оруулагчид, үйлчлүүлэгчид болон зохицуулагчдаас БОНЗ-ын асуудлаар компанийн ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлэх гэсэн хүлээлт нэмэгдэж байгаатай холбоотой. Компаниуд тогтвортой байдлын тайландаа итгэх итгэлийг нэмэгдүүлэх, оролцогч талуудын итгэлийг нэмэгдүүлэх, нэр хүндийн эрсдэлийг бууруулахын тулд сайн дурын үндсэн дээр баталгааны үйлчилгээ авахыг эрмэлздэг. Тогтвортой байдлын тайлагнал ба баталгаажуулалтыг заавал хийлгэх олон улсын шаардлагуудыг дараах хүснэгтэд харуулав:

### Хүснэгт 1. Олон улсын тогтвортой байдлын тайлагналын болон баталгаажуулалтын шаардлага

| Улсын нэр      | Тайлагналын байдал  | Баталгаажуулалтын байдал  |
|----------------|---|---|
| Европын холбоо | Европын холбоо нь Санхүүгийн бус тайлагналын удирдамж (СБТУ) зэрэг зохицуулалтаар дамжуулан тогтвортой байдлын тайлагналыг хөтлөх чиглэлээр тэргүүлэгч байсаар ирсэн. 500-гаас дээш ажилтантай компаниуд нийгэм, хүрээлэн буй орчны янз бүрийн хүчин зүйлийн талаар тайлагнахыг шаарддаг. | Баталгаажуулалтыг заавал хийх албагүй боловч итгэл үнэмшлийг нэмэгдүүлэхийн тулд ихэвчлэн томоохон компаниуд хийлгэдэг.   |
| Франц          | Францын Grenelle II хуулиар 500-гаас дээш ажилтантай компаниуд жилийн тайландаа байгаль орчин, нийгмийн мэдээллийг ил тод болгохыг шаарддаг.  | Санхүүгийн бус мэдээлэлд хөндлөнгийн баталгаажуулалт заавал хийлгэх ёстой. Мөн санхүүгийн бус мэдээллийн тайланг нийтлэхээс өмнө ажилчдын төлөөллийн байгууллагатай зөвлөлдөх шаардлагатай. |

|             |  |   |
|-------------|--|---|
| Итали       | Италийн 254/2016 тоот хуулийн тогтоолоор олон нийтийн ашиг сонирхлын томоохон байгууллагуудад санхүүгийн бус мэдээллийг тайлагнах үүрэг бүхий СБТУ-ийг мөрддөг.  | Баталгаажуулалт нь заавал байх албагүй ч компаниуд тайлангийнхаа найдвартай байдлыг нэмэгдүүлэхийн тулд баталгаажуулахыг илүүд үздэг.   |
| Испани      | Испани улс СБТУ-ийг хэрэгжүүлсэн бөгөөд томоохон компаниудаас санхүүгийн бус тайлан гаргахыг шаарддаг. Испанийн олон компаниуд мөн ТООС-ыг сайн дураараа баримталдаг.  | Баталгаажуулалт нь заавал байх албагүй боловч ихэвчлэн эмзэг салбарын компаниуд хийлгэдэг.  |
| Энэтхэг     | Энэтхэгт Бомбейн хөрөнгийн бирж болон Үндэсний хөрөнгийн биржид бүртгэлтэй 100 шилдэг компани Бизнесийн хариуцлагын тайлангаа ирүүлэх шаардлагатай.  | Хуулиараа заавал биелүүлэх албагүй ч Энэтхэгийн олон томоохон компаниуд тогтвортой байдлын тайландаа хөндлөнгийн баталгааг хийлгэдэг.   |
| Шинэ Зеланд | Уур амьсгалын өөрчлөлтийн санхүүжилтийн мэдээллийг тайлагнах ажлын хэсэгт үндэслэсэн Шинэ Зеландын уур амьсгалын тайлангийн стандартын дагуу хэд хэдэн ангиллын байгууллагууд тайлан гаргах ёстой.   | Баталгаажуулах нь бас заавал биш бөгөөд компаниудын харьцангуй бага хувь нь тайлангаа баталгаажуулсан байна.  |
| Австрали    | Австралийн Үнэт цаас, хөрөнгө оруулалтын хороо нь бизнес эрхлэгчдийг байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөлөлтэй холбоотой аливаа мэдээллийг тайлагнахыг дэмждэг. Австралийн Хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниуд тогтвортой байдлынхаа талаар тайлагнадаг байх ёстой. | Хуульд заагаагүй ч Австралийн олон компаниуд тогтвортой байдлын тайландаа сайн дураараа хөндлөнгийн баталгааг хийлгэдэг. Баталгаажуулалтыг заавал хийлгэх үүрэг болгохыг санал болгож буй Төрийн сангийн зөвлөлдөх баримт бичиг гарсан. |

|          |   |   |
|----------|---|---|
| Сингапур | Сингапурын биржид бүртгэлтэй компаниуд Тогтвортой байдлын тайлангийн удирдамжийн дагуу “дагах эсвэл тайлбарлах” зарчмаар тогтвортой байдлын тайлан гаргах шаардлагатай. | Тогтвортой байдлын тайлангийн хөндлөнгийн баталгаажуулалтыг заавал хийх албагүй ч Сингапурын бирж нь компаниудыг тайландаа итгэх итгэлийг бэхжүүлэхийн тулд хөндлөнгийн баталгаа хийлгэхийг дэмждэг. 2025 оны санхүүгийн жилээс эхлэн хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудад уур амьсгалын талаарх мэдээллийг ил тод болгохыг санал болгож, 2 жилийн дараа хязгаарлалттай баталгаажуулалт шаардах болно. |
|----------|---|---|

*Эх сурвалж: Судлаачдын нэгтгэлээр*

Тогтвортой байдлын тайлагналыг одоогоор олон улс оронд сайн дурын үндсэн дээр хийж байгаа ч заавал тайлагнах шаардлагуудыг хэрэгжүүлэх хандлага ажиглагдаж байна. Байгууллагууд эдгээр журмыг дагаж мөрдөхийг эрмэлзэж байгаа тул энэ нь тогтвортой байдлын баталгааны үйлчилгээний эрэлтийг нэмэгдүүлж болзошгүй юм.

Зохицуулалтын хөндлөнгийн оролцоо нь тогтвортой байдлын баталгааны стандартчилсан хэмжүүр, тайлангийн тогтолцоог бий болгоход чухал үүрэг гүйцэтгэдэг. Үүнд:

- Заавал тайлан гаргах шаардлага: Зохицуулах байгууллагууд нь тогтвортой байдлын тодорхой хэмжүүрийн талаар тайлагнахыг байгууллагуудад үүрэг болгож болно. Энэ нь байгууллагууд холбогдох мэдээллийг тууштай хянаж, ил тод болгоход тусална. Тайлангийн тодорхой удирдамжийг тогтоосноор зохицуулагчид янз бүрийн компаниудын ил тод байдал, харьцуулалтыг хангах боломжтой.
- Стандарт ба хэмжигдэхүүнийг тодорхойлох: Зохицуулагчид тогтвортой байдлын баталгааны стандартчилсан хэмжүүр, тайлагналын хүрээг тодорхойлохын тулд салбарын мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах боломжтой. Эдгээр стандартууд нь тогтвортой байдлын гүйцэтгэлийг хэмжих, тайлагнах нийтлэг хэл, арга зүйгээр хангаж чадна. Зохицуулагчид тодорхой удирдамж бий болгосноор тодорхой бус байдлыг багасгаж, илүү үнэн зөв, найдвартай тайлагналыг бий болгож чадна.

- Дагаж мөрдөх байдалд хяналт тавих: Зохицуулах байгууллага нь тайлагналын шаардлага, стандартын хэрэгжилтэд хяналт тавих боломжтой. Зохицуулагчид аудит, үнэлгээ хийснээр компаниуд тогтоосон хэмжүүр, хүрээг дагаж мөрдөж байгаа эсэхийг баталгаажуулж чадна. Энэ нь тогтвортой байдлын тайлагналын шударга байдлыг хадгалахад тусалж, төөрөгдүүлсэн эсвэл буруу мэдэгдэл гаргахаас сэргийлж чадна.
- Торгууль хэрэгжүүлэх: Зохицуулалтын хөндлөнгийн оролцоо нь тайлагнах шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд торгуулийн арга хэмжээ авж болно. Энэ нь байгууллагуудад стандартчилсан хэмжүүр, тайлагналын тогтолцоог дагаж мөрдөх илүү хүчтэй хөшүүргийг бий болгож чадна.
- Олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах: Зохицуулагчид НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтууд (ТХЗ) зэрэг тогтвортой байдалд чиглэсэн олон улсын байгууллага, санаачилгатай хамтран ажиллах боломжтой. Тайлангийн тогтолцоог дэлхийн жишигт нийцүүлснээр зохицуулагчид хил дамнасан тогтвортой байдал, харьцуулах чадварыг дэмжиж, олон улсын жишиг үнэлгээ, хамтын ажиллагааг хөнгөвчлөх боломжтой.

### **Баталгаажуулалтын ач холбогдол**

Хөндлөнгийн аудиторуудаас үзүүлж буй баталгаажуулалтын үйлчилгээ нь тогтвортой байдлын тайланд агуулагдах мэдээллийн үнэн зөвийг баталгаажуулах, олон улсын стандартад нийцүүлэх, компани өөрийн бодлогыг дагаж мөрдсөн эсэхийг нарийвчлан шалгаж, компанийн тогтвортой үйл ажиллагаанд оролцогч талуудын итгэлийг нэмэгдүүлнэ. Хэд хэдэн судалгааны ажилд дурсдсан баталгаажуулалтын ач холбогдлыг нэгтгэвэл:

- Итгэлцлийг нэмэгдүүлэх: Тогтвортой байдлын тайланд санхүүгийн бус арга хэмжүүрүүдийг авч үздэг бөгөөд эдгээр нь ихэвчлэн субъектив шинж чанартай, стандартчилсан тоон аргачлалгүй байдаг тул буруу тайлагнах эрсдэлтэй. Иймд тайлагнасан өгөгдлийн үнэн зөвийг баталгаажуулахын тулд нарийвчилсан, хараат бус үнэлгээ хийлгэдэг бөгөөд энэ нь тайлангийн найдвартай байдлыг ихээхэн нэмэгдүүлдэг.
- Нийцлийг баталгаажуулах: Баталгаажуулалт нь тогтвортой байдлын тайланг ТООС эсвэл СТООС- Тогтвортой байдал зэрэг холбогдох стандартуудтай нийцэж байгаа эсэхийг баталгаажуулдаг. Эдгээр стандартыг дагаж мөрдөх нь компанийн тогтвортой байдлын тайлагналын чанарыг сайжруулж, компани болон салбаруудын хооронд харьцуулах боломжийг олгодог.
- Эрсдэл ба боломжуудыг тодорхойлох: Баталгаажуулах үйл явц нь

зөвхөн өгөгдөлд дүн шинжилгээ хийхээс гадна тухайн өгөгдлийг нэгтгэхэд оролцдог систем, хяналт, үйл явцуудад дүн шинжилгээ хийдэг. Энэхүү өргөн хүрээний дүн шинжилгээнд үндэслэн баталгаажуулагч нь болзошгүй эрсдэл эсвэл сайжруулах талбарыг тодорхойлсноор компаниудад тогтвортой байдлын стратегиа сайжруулах үнэ цэнэтэй зөвлөмж өгдөг.

- Оролцогч талуудын итгэлийг нэмэгдүүлэх: Байгаль орчны ухамсар нэмэгдэж буй эрин үед оролцогч талууд компаниудын тогтвортой байдлын үйл ажиллагааны ил тод байдлыг улам бүр шаардаж байна. Тогтвортой байдлын тайланг хөндлөнгийн байгууллагаар баталгаажуулсан байх нь эдгээр тайлангийн найдвартай байдалд оролцогч талуудын итгэх итгэлийг ихээхэн нэмэгдүүлдэг.
- Ногоон угаалтыг багасгах: “Ногоон угаалт” гэдэг нь компанийн тогтвортой байдлын талаар хийж буй ажлын талаар худал сэтгэгдэл төрүүлэх, төөрөгдүүлсэн мэдээлэл өгөх үйлдлийг хэлдэг. Баталгаажуулалтын үйлчилгээ нь тайланд дурдсан тогтвортой байдлын мэдэгдлийн үнэн зөвийг баталгаажуулснаар ногоон угаалтыг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг.
- Зах зээлийн ялгаа: Өрсөлдөөнт бизнесийн орчинд байгууллагууд өрсөлдөгчдөөсөө ялгарахын тулд тогтвортой байдлын тайлагналын баталгааг ашигладаг. Баталгаажсан тайлан нь компанийн ил тод байдал, хариуцлагатай байдал, сайн туршлагыг баримталж буйг илэрхийлдэг бөгөөд энэ нь нэр хүндийг өсгөж, хэрэглэгчдийн итгэлийг бий болгож чадна.
- Хөрөнгө оруулалтыг татах: Тогтвортой байдлын тайлагналын баталгаа нь хөрөнгө оруулагчдад компани тогтвортой байдлын гүйцэтгэлээ үнэн зөв тайлагнаж, хариуцлагатай ажиллахыг эрмэлздэг гэсэн итгэлийг өгдөг бөгөөд энэ нь хөрөнгө оруулалтын сонирхлыг нэмэгдүүлэх болно.
- Эрсдэлийг бууруулах: Баталгаажуулалт нь байгууллагын тогтвортой байдлын практикт болзошгүй эмзэг байдлыг тодорхойлж, эрсдэлийг идэвхтэй удирдах боломжийг олгодог. Тогтвортой байдлын асуудал нь хууль эрх зүйн сорилт, зохицуулалтын хориг арга хэмжээ эсвэл нэр хүнд болон санхүүгийн томоохон хохирол учруулж болзошгүй юм.

## Баталгаажуулах үе шат

Баталгаажуулалт нь тайлагнаж буй байгууллагын нөхцөл байдал, түүний дотор тогтвортой байдлын зорилго, тулгарч буй эрсдэлийг ойлгохоос эхэлдэг. Материаллаг байдал эсвэл юу хамгийн чухал болохыг тодорхойлох нь дараагийн чухал зүйл юм. Дараа нь аудиторуд өгөгдлийг цуглуулж, нэгтгэж, үнэн зөв тайлагнасан эсэхийг шалгана. Эцэст нь аудиторуд тогтвортой байдлын тайлангийн найдвартай байдлын талаарх мэргэжлийн дүгнэлтээ багтаасан баталгааны дүгнэлтийг гаргадаг. Баталгаажуулах үйл явц нь ерөнхийдөө дараах 4 үе шатаас бүрдэнэ.

1. Гүйцэтгэх ажлыг хүлээн зөвшөөрөх: Баталгаа гаргагч нь баталгаажуулалтын ажлыг хийж чадах эсэхээ шийддэг. Үүнд гэрээт ажлыг үр дүнтэй гүйцэтгэх баталгаажуулах багийн гишүүдийн ур чадварыг үнэлэх, ёс зүйн болон хараат бус байдлын аливаа асуудлыг авч үзэн, тайлагнагч байгууллагатай баталгаажуулах нөхцөл, хугацаа, зардал, баталгаажуулалтын түвшин, хамрах хүрээ болон хоёр талын үүргийг тохиролцох зэрэг орно.
2. Төлөвлөлт ба эрсдэлийн үнэлгээ: Дараа нь баталгаа гаргагч нь материаллаг байдал (оролцогч талууд болон байгууллагад ихээхэн нөлөөлж болох асуудлууд) тулгуурлан анхаарах гол чиглэлүүдийг тодорхойлох зэрэг баталгаажуулалтын үйл явцыг төлөвлөдөг. Энэ үе шатанд байгууллага, түүний тогтвортой байдлын нөхцөл байдал, эрсдэл, хяналтыг ойлгох зэрэг хамаарна.
3. Гүйцэтгэлийн үе шат: Баталгаажуулах үйл явцын үндсэн үе шат нь тайлагнасан тогтвортой байдлын мэдээллийг баталгаажуулахын тулд нотлох баримт цуглуулах явдал юм. Үүнд мэдээлэл цуглуулах, ярилцлага хийх, бичиг баримтыг шалгах, дотоод хяналтын системийг шалгах зэрэг орно. Шалгах горимууд нь баталгаажуулалтын түвшинээс хамаардаг.
4. Үр дүн ба зөвлөмж: Мэдээлэл, хангалттай болон зохистой нотлох баримтыг цуглуулсны дараа баталгаажуулагч нь байгууллагын тогтвортой байдлын тайланд гарсан аливаа зөрчлийг тодорхойлж, сайжруулах зөвлөмжийг өгдөг. Эцэст нь баталгаа гаргагч нь баталгааны албан ёсны дүгнэлт гаргадаг бөгөөд энэ дүгнэлтийг ихэвчлэн байгууллагын тогтвортой байдлын тайланд хавсаргасан байдаг. Энэхүү дүгнэлтэд тайлангийн найдвартай байдал, материаллаг алдаа илэрсэн эсэх талаар болон баталгаажуулалтын түвшинг (хязгаарлалттай эсвэл зохистой) агуулсан байна.



## Баталгаажуулалтын түвшин

### Хүснэгт 2. Зохистой болон хязгаарлалттай баталгаажуулалтын ялгаа

|   | Хязгаарлалттай баталгаа  | Зохистой баталгаа  |
|---|--|--|
| Баталгаажуулалтын түвшин  | Бага   | Их   |
| Сэдвийн ойлголт   | Материаллаг алдаа гарах магадлалтай газруудыг тодорхойлно.   | Материаллаг буруу тайлагналын эрсдэлийг тодорхойлж, үнэлнэ.  |
| Сэдвийн талаарх мэдээлэл  | Сэдвийг бэлтгэх үйл явцыг авч үздэг.   | Сэдвийг бэлтгэж буй дотоод хяналтыг авч үздэг.   |
| Тайлагналын томоохон үйл явцын баримтжуулалт                      | Зөвхөн сэдэвтэй холбоотой чухал тайлагнах үйл явцын талаар ойлголт авч баримтжуулах шаардлагатай.                          | Үйл явцын бүх үе шатыг баримтжуулах, жишээ нь эхлүүлэх, бүртгэх, боловсруулах, бүртгэх үе шатуудыг баримтжуулах шаардлагатай               |
| Чухал үйл явцад холбогдох хяналтын алхмуудын баримтжуулалт        | Шаардлагагүй.  | Хэрвээ дотоод хяналтад итгэх стратеги ашиглах бол холбогдох дотоод хяналтыг баримтжуулна.  |
| Дотоод хяналтын загварыг ойлгох, үнэлэх                           | А. Хяналтын орчин<br>Б. Мэдээллийн систем<br>В. Байгууллагын эрсдэлийн үнэлгээний үйл явцын үр дүнгийн талаар ойлголт авах | Нэмэлтээр, батлах түвшин болон хяналтын мониторингийн хувьд материаллаг алдаа гарах эрсдлийн үнэлгээний талаар ойлголт авах                |
| Хяналтад итгэх стратегийг сонгох                                  | Ихэвчлэн дотоод хяналтад итгэх стратеги ашиглахгүй.  | Хэрвээ дотоод хяналт үр дүнтэй ажилладаг гэсэн хүлээлттэй байвал дотоод хяналтад итгэх стратеги ашиглаж болно.                             |
| Хяналтын тест   | Ихэвчлэн дотоод хяналтыг тестэдэггүй.  | Хяналт нь үр дүнтэй ажилладаг талаар дүгнэлтэд хүрэхийн тулд хяналтын тест хийнэ.  |
| Мэдээллийн технологи болон мэдээлэл технологийн ерөнхий хяналтууд | Ихэвчлэн мэдээллийн технологийн ерөнхий хяналтыг тестлэхгүй, итгэх стратеги ашиглахгүй.                                    | Хэрвээ дотоод хяналтад итгэх стратеги ашиглавал үр дүнтэй мэдээллийн технологийн ерөнхий хяналттай эсэхийг тодорхойлно.                    |
| Эрсдэлийн үнэлгээ   | Уламжлалт эрсдэлийг их эсвэл бага эсэхийг үнэлдэг. Батламжийн түвшинд эрсдэлийг үнэлэхгүй.                                 | Тогтвортой байдлын тайлангийн түвшинд болон батламжийн түвшинд материаллаг алдааны эрсдэлийг таньж үнэлэх. Эрсдэлийн хосолсон үнэлгээ хийх |

|          |  |  |
|----------|--|--|
| Горимууд | Анализ, ярилцлагын горимууд. Жишээ нь, ажиглалт, зөрүүгийн анализ, харьцааны анализ гэх мэт  | Бодит тест, хяналтын тест, нарийвчилсэн тест. Жишээлбэл, дахин гүйцэтгэх, дахин тооцоолох, тулган баталгаажуулалт болон статистик түүвэр гэх мэт |
| Тайлан   | Дүгнэлт- Бидний үйл ажиллагаа болон олж авсан нотлох баримтад тулгуурлан мэдээллийг шалгуурт нийцүүлэхийн тулд ямар нэгэн материаллаг өөрчлөлт хийсэн зүйл ажигласангүй. | Дүгнэлт- Бидний бодлоор тухайн сэдвийг бүх материаллаг талаас нь шалгуур үзүүлэлтийн дагуу танилцуулсан болно.                                   |

*Эх сурвалж: Судлаачдын харьцуулалтаар*

### **Монгол улсын тогтвортой байдлын тайлагнал ба баталгаажуулалтын өнөөгийн байдлын судалгаа, дүгнэлт**

Тогтвортой хөрөнгө оруулалтын зах зээл өргөжихийн хэрээр илүү олон хөрөнгө оруулагчид компаниудын тогтвортой байдлын тайланг сонирхож байна. Гэсэн хэдий ч хөрөнгө оруулагчид компанийн тогтвортой байдлын талаарх мэдээлэлд эргэлздэг учир нь тэдний цөөхөн нь хөндлөнгийн аудитад хамрагддаг ба мэдээлэл нь тэдний хүлээлтийг хангах нь ховор. Тогтвортой Санхүүжилтийн Холбооны судалгаанд хамрагдсан бараг бүх хөрөнгө оруулагчид буюу 97 хувь нь тогтвортой байдлын талаарх мэдээллийг ямар нэгэн байдлаар шалгах ёстой гэж, 67 хувь нь тогтвортой байдлын аудит нь санхүүгийн аудит шиг зайлшгүй хийгдэх ёстой гэж хариулсан байна.

Одоогоор Монгол Улсад үндэсний хэмжээнд БОНЗ, тогтвортой байдлын тайлагналын мэргэшсэн баталгаа гаргадаг байгууллага байхгүй ч компаниуд тус улсад салбараа нээгээд байгаа олон улсын Том 4 хэмээн нэрлэгддэг аудитын компаниар баталгаа гаргуулах боломжтой. Компаниуд тогтвортой байдлын тайлан гаргаж хэвшихийн хэрээр тайлагналын баталгаа гаргах шинэ зах зээл бий болж байна. Баталгаажуулалт хийлгэснээр төөрөгдүүлсэн буюу буруу ташаа мэдээллийг задруулахтай холбоотой компанийн нэр хүндэд учрах эрсдэл болон зах зээлийн эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд тусална (СЗХ болон бусад байгууллагууд, БОНЗ, Тогтвортой байдлын тайлагналын удирдамж, 2022).


Байгууллагууд тогтвортой байдлын төлөөх амлалтаа харуулж, оролцогч талуудын хүлээлтийг хангахыг хичээхийн хэрээр тогтвортой байдлын тайлангаа хараат бусаар баталгаажуулах хэрэгцээ улам бүр нэмэгдэх болно.

МХБ-ийн вэб хуудсанд 21 хувьцаат компани БОНЗ-ын тайланг бэлтгэн нийтэлсэн бөгөөд давхардсан тайлангуудыг хассан болон “Монголын хөрөнгийн

бирж” ТӨХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 08 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журам”-ын 1 дүгээр хавсралтын дагуу тайлагнасан тайлангуудыг шүүн авч үзэхэд 7 компани үлдсэн бөгөөд энэхүү 7 компани буюу АПУ ХК, Говь ХК, Инвексдор ББСБ ХК, Сүү ХК, Төрийн банк ХК, Эрэнцав ХК болон МИК ХК-ийн хүрээнд судалгааг хийсэн болно.

СЗХ болон бусад байгууллагуудын хамтран гаргасан Тогтвортой байдал, БОНЗ-ын тайлан гаргах удирдамжийн төслийн багаас тайлагналын олон улсын аргачлал, стандартуудын зөвлөмжүүдтэй нийцүүлж, тайлагнавал зохих БОНЗ-ын 30 үзүүлэлтийг тодорхойлсон бөгөөд эдгээр нь зайлшгүй тайлагнах шаардлагатай суурь үзүүлэлтүүд юм. Тогтвортой байдлын тайланг илүү дэлгэрэнгүй гаргах зорилт тавьж буй компаниудад зориулан дээрх шалгуур үзүүлэлтүүдийг Тайлагналын GRI, SASB, TCFD, IFRS зэрэг олон улсын стандартууд болон ТХЗ-уудын үзүүлэлтүүдтэй харьцуулан судалж боловсруулсан байна. Эдгээр 30 шалгуур үзүүлэлтийн судалгаанд хамрагдсан 7 компанийн тайлагналын байдлыг доорх графикаар дундажтай харьцуулан харуулав.

**График 1. Судалгааны үр дүн, дундажтай харьцуулсан байдал**



Эх сурвалж: Судлаачдын судалгаагаар

Судалгааны үр дүнгээс харахад, компаниуд Засаглалын шалгуур үзүүлэлтүүдийг 86-100%-тай, Нийгмийн шалгуур үзүүлэлтүүдийг 57-89%-тай, Тогтвортой хөгжлийн удирдлагын тогтолцооны шалгуур үзүүлэлтүүдийг 33-86%-тай хангаж ажилласан бол хамгийн хангалтгүй буюу сайжруулах шаардлагатай нь Байгаль орчны шалгуур үзүүлэлтүүд 14-64%-тай байна. Бусад үзүүлэлтүүдтэй харьцуулахад компаниуд байгаль орчны шалгуур үзүүлэлтийг тайлагнахад хүндрэлтэй байгаа бөгөөд үүн дотроос уур амьсгалын өөрчлөлт болон хүлэмжийн хийн ялгарлыг хэмжих, тайлагнахад анхаарал хандуулах шаардлагатай харагдаж байна.

Тогтвортой хөгжлийн бодлого зохицуулалт 36%, тогтвортой байдлын тайлагнал 33% байгаа ба энэ нь компаниуд тогтвортой хөгжлийн тусгайлсан бодлого, зорилт, журам боловсруулан мөрдөх, тогтвортой байдлын тайланг олон улсын стандартын дагуу бэлтгэж тайлагнахаас гадна хөндлөнгийн баталгаажуулалт хийлгэх хэрэгтэйг тус тус харуулж байгаа юм.

БОНЗ, Тогтвортой байдлын тайлагналын удирдамжийн Заавал тайлагнах үндсэн үзүүлэлтийн MS7. Тогтвортой байдлын тайлагнал, баталгаажуулалтад MS7.3 Тогтвортой байдлын талаарх мэдээлэлдээ хараат бус гуравдагч этгээдээр баталгаа гаргуулдаг уу? (Тийм/Үгүй) гэх асуулт байх боловч “Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журам”-д энэ асуулт байхгүй байгаа нь зарим компаниудын Байгаль орчин, нийгэм засаглалын үйл ажиллагааны тайланд баталгаа хийлгэсэн эсэх талаар дурдахгүй байхад хүргэжээ. Судалгаанд хамрагдсан 4 компани энэхүү хараат бус баталгаа гаргуулсан уу гэх асуултад “Үгүй” гэсэн хариулт өгсөн байна.

### **Тогтвортой байдлын тайланг баталгаажуулах зөвлөмж**

Тогтвортой байдлын тайлагналын баталгаа нь найдвартай байдлыг харуулах, тайлагналын ерөнхий үйл явцыг сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Тогтвортой байдлын тайлагналын баталгаажуулалтын үйл явцыг сайжруулахын тулд дор дурдсан зөвлөмжүүдийг санал болгож байна.

- Нэр хүндтэй баталгаажуулагчийг сонгох: Итгэл үнэмшил, бодитой байдлыг хангахын тулд компаниуд өөрсдийн туршлага, бие даасан байдал, өндөр чанарын стандартаараа алдартай хөндлөнгийн баталгаажуулагчийг сонгох хэрэгтэй.
- Мэдээллийн удирдлагын системийг бэхжүүлэх: Тогтвортой байдлын мэдээллийн үнэн зөв, найдвартай байдлыг нэмэгдүүлэхийн тулд компаниуд мэдээлэл цуглуулах, удирдах, тайлагнах хүчирхэг системд хөрөнгө оруулах ёстой. Өгөгдлийн үр дүнтэй менежмент нь баталгаажуулалтын үйл явцыг илүү үр дүнтэй болгож чадна.

- Сургалт ба чадавхийг бэхжүүлэх: Байгууллагууд тогтвортой байдлын тайлагналын талаарх ажилтнуудын ойлголтыг сайжруулах, мэдээлэл үнэн зөв цуглуулах, ил тод байхын ач холбогдлыг дээшлүүлэхийн тулд сургалт, чадавхийг бэхжүүлэхэд хөрөнгө оруулалт хийх ёстой.
- Тогтмол харилцаа холбоо: Компанийн тогтвортой байдлын санаачилгуудын цар хүрээ, үр нөлөөг бүрэн ойлгохын тулд баталгаа гаргагчид болон тогтвортой байдлын тайланг хариуцдаг компанийн дотоод багийн хооронд тогтмол харилцах шаардлагатай.
- Хүлээн зөвшөөрөгдсөн баталгаажуулалтын стандартыг ашиглах: Баталгаажуулалтын шинэчилсэн олон улсын стандарт 3000 зэрэг хүлээн зөвшөөрөгдсөн стандартууд дээр үндэслэн хийх ёстой. Ийм стандартыг ашиглах нь оролцогч талуудад баталгаажуулалтын ажлын чанарыг дүгнэх боломжийг олгодог. 2023 оны 8-р сард нийтлэгдсэн ОУСС 5000 “Тогтвортой байдлын баталгаажуулалтын ажилд тавигдах ерөнхий шаардлагууд” төсөл нь ОУС 3000-ыг орлох болно. Эцсийн стандарт 2024 оны эцэст нийтлэгдэнэ гэсэн хүлээлттэй байна.
- Тодорхой баталгааны мэдэгдэл: Мэдэгдэлд баталгааны түвшин (хязгаарлалттай эсвэл зохистой), хамрах хүрээ, ашигласан стандартууд, гол дүгнэлт, зөвлөмжийг тодорхой дурдах ёстой. Энэхүү ил тод байдал нь оролцогч талуудын итгэлийг эрс нэмэгдүүлж чадна.
- Тасралтгүй сайжруулалт: Баталгаажуулах үйл явцыг сургалтын хэрэгсэл гэж үзэх хэрэгтэй. Тогтвортой байдлын тайланг тасралтгүй сайжруулахын тулд санал зөвлөмжийг анхаарч үзэх хэрэгтэй.

Эдгээр зөвлөмжийг хэрэгжүүлснээр тогтвортой байдлын тайлангийн үр нөлөө, найдвартай байдлыг мэдэгдэхүйц нэмэгдүүлэх боломжтой. Эдгээр шилдэг туршлагыг хэрэгжүүлснээр компаниуд оролцогч талуудын итгэлийг нэмэгдүүлж, тогтвортой байдалтай холбоотой эрсдэл, боломжуудыг тодорхойлж, шийдвэрлэж, бизнесийн илүү тогтвортой ирээдүйд хувь нэмрээ оруулж чадна.

Тармизи Ахмад нарын 2014 оны Фортуне 500 компанийн 135 англи хэл дээрх тогтвортой байдлын баталгаажуулалтын тайлангийн чанарын судалгаа хийхдээ ашигласан шалгуур үзүүлэлтүүдийг тогтвортой байдлын баталгаажуулалтын тайланд агуулагдаж байвал зохистой гэж үзлээ.

**Хүснэгт 3. Тогтвортой байдлын баталгаажуулалтын тайлангийн загвар**

|                                 |  |
|---------------------------------|--|
| Тайлангийн хэрэглэгчдэд хаяглах | Баталгаажуулалтын тайлан эсвэл мэдэгдлийн зорилгот хэрэглэгчид (жишээлбэл, оролцогч талууд эсвэл Төлөөлөн удирдах зөвлөл, тайланд гарын үсэг зурах үүрэгтэй гүйцэтгэх удирдлага эсвэл хороо гэх мэт)                             |
| Баталгаажуулагчийн нэр, хаяг    | Баталгаажуулах ажлыг гүйцэтгэсэн байгууллагын нэр, хаяг  |
| Хариуцлага                      | Ерөнхий зорилго эсвэл бүрэн эрх, тайлагнагч болон баталгаажуулагчийн үүрэг хариуцлагын тухай мэдэгдэл  |
| Хараат бус байдал               | Баталгаажуулагчийн хараат бус байдлын талаар мэдэгдэл  |
| Хамрах хүрээ                    | Баталгаажуулалтын үйл явцад ямар стандартад хамрагдахыг тодорхойлсон мэдэгдэл  |
| Тайлан бэлтгэх шалгуур          | Баталгаа гаргагчийн арга барилыг чиглүүлэхийн тулд баталгаажуулагчийн ашигласан стандарт (жишээ нь ISAE 3000, AA1000AS эсвэл үндэсний болон салбарын стандартууд)  |
| Баталгааны түвшин               | Баталгаажуулагчид зохистой баталгаа эсвэл хязгаарлалттай баталгаа гэсэн хоёр түвшинг санал болгодог.   |
| Хязгаарлалтууд                  | Баталгаажуулсан мэдээллийн хамрах хүрээ эсвэл баталгаажуулалтын үйл ажиллагаанд зарим өгөгдөл байхгүй байх, мэдээлэл цуглуулах системд гарсан өөрчлөлт зэрэг анхаарал татахуйц хязгаарлалтын талаарх тайлбар.                    |
| Гүйцэтгэсэн хяналтын горимууд   | Баталгаажуулалтад хамрагдсан тогтвортой байдлын талаарх тодруулгын үнэн зөв эсэхийг шалгахын тулд гүйцэтгэсэн арга хэмжээний хураангуй   |
| Материаллаг түвшин              | Оролцогч талуудын хувьд материаллаг түвшин   |
| Дүгнэлт                         | Баталгаажсан мэдээллийг үнэн зөв, бодитой, алдаагүй, тайлангийн шалгуурын дагуу тайлагнасан эсэх талаар мэдэгдэл. Дүгнэлтийн үг хэллэг нь ашигласан стандарт, баталгааны түвшин, баталгаажуулагчаас хамааран өөр өөр байх болно. |

|                     |  |
|---------------------|--|
| Зөвлөмж             | Зарим баталгааны тайланд цаашид авах арга хэмжээ, анхаарал хандуулах зөвлөмжүүд багтсан байдаг. Олон нийтэд зарласан баталгааны тайлан эсвэл мэдэгдлээс гадна баталгаажуулагч нь удирдлага эсвэл ТУЗ-д хэлэлцэх нарийвчилсан дүгнэлт, зөвлөмж бүхий тусдаа “удирдлагын захидал” бэлтгэж болно. |
| Гарын үсэг ба огноо | Баталгаа гаргагч талаас хариуцлага хүлээх партнерын гарын үсэг ба тамга, огноо   |

*Эх сурвалж: Achmad et al., 2017*

### **Практикт тулгарч буй асуудал ба түүнийг шийдвэрлэх арга зам**

Тогтвортой байдлын баталгаажуулалтын үйлчилгээний зах зээл хөгжиж буй хэвээр байгаа бөгөөд анхаарах ёстой бэрхшээл, зүйлс байдгийг тэмдэглэх нь зүйтэй.

Тогтвортой байдлын баталгаажуулалт хийхэд тулгардаг нийтлэг бэрхшээлүүд нь:

1. Хязгаарлагдмал мэдээлэл: Тогтвортой байдлын гүйцэтгэлийн талаар үнэн зөв, иж бүрэн мэдээлэл цуглуулах нь хязгаарлагдмал дотоод мэдээллийн удирдлагын системтэй компаниудад бэрхшээлтэй байж болно.

2. Стандартчилагдсан хэмжүүр дутмаг: Бүх нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэмжүүр байхгүй байгаа нь янз бүрийн байгууллага эсвэл салбаруудын тогтвортой байдлын гүйцэтгэлийг харьцуулахад хүндрэл учруулдаг. Энэ нь тайлагналын зөрчилд хүргэж, зорилот болон жишиг үзүүлэлтүүдийг тогтооход хүндрэл учруулж болзошгүй юм.

3. Оролцогч талуудын оролцоо: Баталгаажуулах үйл явцын туршид оролцогч талуудыг үр дүнтэй татан оролцуулах нь бэрхшээлтэй байж болно. Хөрөнгө оруулагчид, төрийн бус байгууллагууд, ажилчид, үйлчлүүлэгчид зэрэг дотоод болон гадаад янз бүрийн оролцогч талуудтай тодорхой харилцаа холбоо, зохицуулалт, хамтын ажиллагааг шаарддаг.

4. Материалаг асуудлуудыг тодорхойлох: Тогтвортой байдлын аль асуудал нь байгууллагад хамгийн чухал, хамааралтай болохыг тодорхойлох нь субъектив бөгөөд төвөгтэй байж болно. Үүнд дотоод тэргүүлэх чиглэл болон гадны оролцогч талуудын хүлээлтийг харгалзан үзэх шаардлагатай.

5. Хязгаарлагдмал нөөц: Тогтвортой байдлын өгөгдөл, мэдээллийн үнэн зөв, найдвартай байдлыг үнэлэхэд ихэвчлэн нарийн төвөгтэй, цаг хугацаа

шаардсан баталгаажуулалтын горимууд гүйцэтгэх хэрэгтэй болдог. Нийгмийн нөлөөлөл эсвэл олон нийтийн оролцоо зэрэг биет бус мэдээллийг шалгах үед энэ нь ялангуяа хэцүү байж болно.

6. Тогтвортой байдлыг бизнесийн үндсэн практикт нэгтгэх: Байгууллагын бизнесийн үндсэн практикт тогтвортой байдлыг тусгах нь ялангуяа одоо байгаа үйл явц, бүтэц, соёлд өөрчлөлт оруулах шаардлагатай үед бэрхшээлтэй байж болно. Тогтвортой байдлын зорилгыг бизнесийн ерөнхий зорилтуудтай уялдуулах нь урт хугацааны амжилтанд зайлшгүй шаардлагатай.

7. Хөгжиж буй дүрэм журам, стандартууд: Хөгжиж буй зохицуулалтын тогтолцоо, салбарын стандартыг дагаж мөрдөх нь бус нутаг, салбараас хамаарч өөр өөр байдаг тул хүндрэлтэй байж болно. Мэдээлэлтэй байх, эдгээр өөрчлөлтийг дагаж мөрдөх нь үнэн зөв тайлагнах, баталгаажуулах үйл явцад маш чухал юм.

8. Хөрөнгө оруулагчийн байр сууринаас харахад тогтвортой байдлын талаарх тодруулга нь санхүүгийн гүйцэтгэлтэй сул холбоотой, нэг компаниас нөгөө компанитай харьцуулахад хэцүү, найдвартай биш байх хандлагатай байдаг.

Тогтвортой байдлын баталгаанд стандартчилагдсан хэмжүүр дутагдаж буй асуудлыг шийдвэрлэх боломжит шийдэл нь:

1. Хамтын ажиллагаа ба оролцоо: Стандартчилсан хэмжигдэхүүн болон тайлагналын тогтолцоог боловсруулахад салбарын хэмжээнд оролцогч талуудтай хамтарч ажиллах, тэдний оролцоог дэмжих. Энэ нь бүх байгууллагууд тогтвортой, харьцуулж болохуйц өгөгдлийг ашиглаж байгаа эсэхийг баталгаажуулахад тусалдаг.

2. Зохицуулалтын хөндлөнгийн оролцоо: Байгууллагуудаас тогтвортой байдлын тодорхой хэмжүүрүүдийг тайлагнаж, тодорхой стандартыг дагаж мөрдөхийг шаарддаг засгийн газрын зохицуулалтыг сурталчлах хэрэгтэй. Энэ нь өрсөлдөөний тэгш талбарыг бий болгож, тайлагнах практикт тууштай байдлыг бий болгоход тусална.

3. Сайн дурын тайлагналын санаачилга: ТООС эсвэл Тогтвортой байдлын нягтлан бодох бүртгэлийн стандартын зөвлөл, СТОУС зэрэг сайн дурын тайлагналын санаачлагуудад оролцох. Эдгээр санаачилгууд нь тогтвортой байдлын үндсэн үзүүлэлтүүдийн талаар тайлагнах байгууллагуудад удирдамж, хүрээг бүрдүүлдэг.

4. Салбарт хамаарах стандартууд: Салбар бүрийн өвөрмөц сорилт, боломжуудыг шийдвэрлэх салбарын онцлогт тохирсон стандарт, хэмжүүрүүдийг боловсруулах. Энэ нь илүү үнэн зөв, хамааралтай тайлагнах, байгууллага хоорондын харьцуулалт хийх боломжийг олгоно.



5. Технологи ба өгөгдлийн шийдлүүд: Тайлангийн үйл явцыг оновчтой болгох, мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийхэд хялбар болгохын тулд технологи, өгөгдлийн шийдлүүдийг ашиглах. Энэ нь байгууллагуудад тогтвортой байдлын хэмжүүрүүдийг илүү үр дүнтэй цуглуулж, хянахад тусалж, шийдвэр гаргах, ил тод байдлыг сайжруулах боломжийг олгоно. Жишээлбэл, хиймэл оюун ухааныг томоохон хэмжээтэй өгөгдлийг шинжлэхэд ашиглах нь их хэмжээний өгөгдлийг илүү үр дүнтэй удирдах, илүү гүнзгий ойлголттой болох, тайлагнах, баталгаажуулах үйл явцын нарийвчлалыг сайжруулахад тусална.

### **СТОУС- Тогтвортой байдлын тодруулга**

2024 оны 1 дүгээр сарын 1-ээс эхлэн мөрдөх “СТОУС Тогтвортой байдлын тодруулга”-ын 1,2-р стандартад авч үзсэн уур амьсгалтай холбоотой тодруулгын шаардлага тэр чигтээ бүх компанид шууд нөлөөтэй, өөрөөр хэлбэл, СТОУС-д нийцүүлэн тайлангаа гаргадаг аж ахуйн нэгж, байгууллагуудаас уг стандартыг үл мөрдөх буюу чөлөөлөгдөх байгууллага байхгүй гэсэн үг юм. СТОУС ТБ1 ба СТОУС ТБ2-ыг нэг багц стандарт гэж үзнэ. Эдгээр нь хоорондоо нягт уялдаатай, хамтад нь хэрэгжүүлэхээр боловсруулан баталсан стандарт юм.

СТОУС: Тогтвортой байдал 1 (СТОУС ТБ1)- Тогтвортой байдалд хамаарах санхүүгийн мэдээллийг ил тод болгох буюу тодруулахад тавигдах ерөнхий шаардлагуудыг уг стандартад тусгасан байна. Онцын ач холбогдолгүй мэдээллийг тодруулахад хэт их цаг хугацаа, өртөг зардал зарцуулж болзошгүй учир бүх мэдээллийг энд тусгах шаардлагагүй. Ерөнхий зорилготой санхүүгийн тайлан, жишээлбэл удирдлагын тайлбар, жилийн тайланд шууд тусган тодруулна. Мэдээж тусгах бүх мэдээллээ санхүүгийн тайлантайгаа холбоно. Энэ нь ижил таамаглал ба тооцооллыг ашиглах, толилуулгын ижил валют ашиглах, тогтвортой байдал ба санхүүгийн мэдээлэл хоорондын уялдаа холбоог хангана гэсэн үг юм.

СТОУС ТБ2 нь Стратеги, засаглал, эрсдэлийн удирдлага буюу уур амьсгалын болон хэмжүүр ба зорилт буюу уур амьсгалтай холбоотой гэсэн хоёр үндсэн ангиллаар мэдээллийг тодруулахыг компаниудаас шаардаж байгаа.

### **Тогтвортой байдлын тайлангийн баталгааны талаарх ирээдүйн судалгааны саналууд:**

- Оролцогч талуудын шийдвэрт үзүүлэх нөлөө: Тогтвортой байдлын баталгаатай тайлан нь хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгч, ажилчид гэх мэт янз бүрийн оролцогч талуудын шийдвэрт хэрхэн нөлөөлж байгааг ойлгохын тулд судалгаа хийж болно.

- Ногоон угаалт ба баталгаажуулалт: Ногоон угаалттай холбоотой санаа зовоосон асуудал нэмэгдэж байгаа тул эдгээр үйлдлээс урьдчилан сэргийлэхэд баталгааны үйлчилгээ хэр үр дүнтэй болохыг судалж үзэх боломжтой.
- Харьцуулалтын судалгаа: Баталгаажуулалтын ялгаатай түвшин (зохистой ба хязгаарлалттай) нь тайлангийн найдвартай байдал болон компанийн тогтвортой байдлын ерөнхий үнэлгээнд хэрхэн нөлөөлж байгааг харахын тулд харьцуулсан судалгааг хийж болно.
- Технологийн үүрэг: Тогтвортой байдлын тайланг баталгаажуулах үйл явцад хиймэл оюун ухаан, том өгөгдөл зэрэг технологийн хэрэгслийг ашиглах талаар нэмэлт судалгаа хийж болно.
- Баталгаажуулагчийг сонгох: Компаниуд баталгаа гаргагчийг сонгохдоо ашигладаг шалгуурууд болон энэ сонголт нь баталгаажуулалтын үр дүнд хэрхэн нөлөөлж буйд анхаарлаа хандуулж болно.
- Шилдэг туршлага: Тогтвортой байдлын тайлагналын баталгаатай холбоотой өөр өөр салбаруудад мөрдөж буй шилдэг туршлагыг илүү гүнзгий судлах нь үнэ цэнэтэй ойлголт, жишиг үзүүлэлтүүдийг өгөх болно.
- Зохицуулалтын нөлөөлөл: Тогтвортой байдлын тайлагналд хууль эрх зүй, заавал хийлгэх шаардлага, зохицуулалтын нөлөөллийн судалгаа

## Дүгнэлт

Дүгнэж хэлэхэд, тогтвортой байдлын тайлагналын баталгаажуулалт нь тогтвортой байдлын асуудлаар байгууллагуудын ил тод байдлыг илүү өргөн хүрээтэй илэрхийлэхэд үнэ цэнэтэй хэрэгсэл юм. Бизнесүүдэд тайлангийнхаа үнэн зөвийг баталгаажуулж, БОНЗ-д үзүүлэх нөлөөллийн хариуцлагыг хүлээх боломжийг олгосноор баталгаажуулалтын үйлчилгээ нь дэлхийн эдийн засгийг тогтвортой байлгахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэхүү ногоон шилжилтийг хүлээн зөвшөөрч, тогтвортой байдлын найдвартай тайлан гаргахад бэлэн байгаа компаниудад баталгаажуулалт хийлгэх нь нэр хүнд болон урт хугацааны амжилтад ашиг тусаа өгөх болно.

Дээрх дүгнэлтэд үндэслэн дараах саналуудыг дэвшүүлж байна.

- Компаниудын БОНЗ-ын тайлагналын мэдээллийн нэгдсэн сан бий болгож, цуглуулсан тоо мэдээг эрдэм шинжилгээний эргэлтэд оруулах
- Байгууллагуудын БОНЗ-ын тайланг хариуцсан ажилтнууд болон удирдлагуудын ур чадвар, стандартын ойлголтыг сайжруулах зорилгоор тогтмол сургалтад хамруулах

- Энэ чиглэлийн судалгаа, шинжилгээний ажлууд цөөн байгаа тул БОНЗ-ын тайлагнал, баталгаажуулалтыг хөгжүүлэх, боловсронгуй болгох үүднээс төр, эрдэм шинжилгээний байгууллагууд энэ асуудлаар тодорхой арга хэмжээ авч ажиллах шаардлагатай.

### **Ашигласан материал**

- Achmad, T., Faisal, F., & Ulum, M. B. (2017). Nature Of Information Provided And Quality Of Sustainability Reports Assurance Statements Of Fortune Global 500 Companies. *Journal of Applied Business Research (JABR)*, 33(5), 1023–1034.
- Farooq, M. B., & De Villiers, C. (2019). Sustainability assurance: who are the assurance providers and what do they do?. *Challenges in managing sustainable business: Reporting, taxation, ethics and governance*, 137-154.
- Global Reporting Initiative. (2013). The external assurance of sustainability reporting. *Research and Development Series*. Retrieved May, 1, 2014.
- Yan, M., Jia, F., Chen, L., & Yan, F. (2022). Assurance process for sustainability reporting: towards a conceptual framework. *Journal of Cleaner Production*, 134156.
- СЗХ- Санхүүгийн Зохицуулах Хороо болон бусад байгууллагууд, БОНЗ, Тогтвортой байдлын тайлагналын удирдамж 2022
- <https://www.mse.mn/> and <https://www.1212.mn/>